



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/36

Мөрөн сум

Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл  
ажлыг хангах, хяналт тавих, гүйцэтгэлийг  
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 01 албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, хяналт тавих, гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

|                       |              |                                       |
|-----------------------|--------------|---------------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ц.Болорцэцэг | Санхүү албаны дарга                   |
| Нарийн бичгийн дарга: | А.Алимаа     | Нийгмийн бодлогын мэргэжилтэн         |
| Гишүүдэд:             | Ш.Баасандорж | Байгаль орчны хяналтын улсын байцаагч |
|                       | Э.Балчиндорж | Цагаан толгой багийн Засаг дарга      |
|                       | Г. Бат       | Газрын даамал                         |

2. Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлийн дагуу төлөвлөгөө боловсруулан, шаардагдах төсвийн тооцоо гаргаж батлуулж, төлөвлөгөөний дагуу шуурхай ажил зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Ц.Болорцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлыг 2025 оны 09 дугаар сарын 10-ний дотор хүлээн авч Засаг даргын Тамгын даргад танилцуулахыг ажлын хэсгийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ

Мөрөн сумын Засаг даргын  
Тамгын газрын даргын 2025 оны 07 дугаар  
сарын 22 өдрийн 1/36 тоот тушаалын хавсралт

## БАЙГУУЛЛАГЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСЭГТ ӨГӨХ ЧИГЛЭЛ

Байгууллагын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэлийг шалгаж, цаг агаарын эрс хүйтрэл, учирч болзошгүй эрсдэл, хүндрэл бэрхшээлийг хохирол багатай даван туулахад шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажиллах

Үүнд:

1.ЗДТГ, Ундны усны худаг, Ахмадын байр, Ахуй үйлчилгээ, Цэвэр усны төхөөрөмж, Халуун усны байруудын хана, тааз, дээвэр, шал, цонх, хаалганы дулаан алдалтыг шалгаж битүүмжлэл, дулаалга хийлгэх.

2.Дээрх байгууламжуудын гадна орчинд цэвэрлэгээг үйлчилгээ хийлгэх

3.Өрөө тасалгаануудын дулаан хангамжийн шугам, пар, хий авах крант зэргийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, дулаан авхад бэлтгэж, засвар үйлчилгээ хийлгэж, бэлтгэл бэлэн байдлын хангуулах

4.Харьяа объектуудын цахилгааны монтаж, гэрлийн утсанд мэргэжлийн байгууллагатай хамтарч үзлэг, засвар үйлчилгээ хийж өвлийн улиралд найдвартай ажиллах бэлтгэлийг хангуулах

5.Дулааны болон цэвэр усны шугамын худгуудад засвар үйлчилгээ, дулаалга хийлгэж хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх

6.Авто техникүүдэд хийх тосолгоо, засвар үйлчилгээг чанартай хийлгэж үйлчилгээний найдвартай байдлыг хангах, өвөл ашиглахгүй техникүүдийг парклаж, засвар үйлчилгээ хийх хөлдөлт, ялзралтаас хамгаалах ажлыг зохион байгуулж хийх,

7.Өвлийн улиралд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хийгдэх засвар үйлчилгээний санхүүгийн тооцоог гаргаж батлуулах

000